

МУИС-ийн сүлжээнээс чөлөөтэй хандаж болох сангууд.



### 1. EBSCO Host

МУИС-ийн эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн санг хүртээмжтэй болгох зорилгоор олон улсад өргөн хэрэглэгддэг EBSCO HOST нэгдсэн мэдээллийн сангаас

- eBook Academic Collection
- Academic Search Premier
- Business Source Premier

гурван багцыг захиалсан бөгөөд 2018 оны 11 сар хүртэл ашиглах боломжтой.



### 2. ROYAL SOCIETY

Эрдэм шинжилгээний хэвлэлийн салбарт 350 жилийн түүхтэй Их Британийн Вангийн Нийгэмлэгээс өндөр импакттай сэтгүүлүүдийг хэвлэн гаргадаг бөгөөд эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийнхээ хамгийн анхны дугааруудыг олон нийтэд нээлттэй болгоод байна.



### 3. ANNUAL REVIEWS

1932 оноос хойш шинжлэх ухааны салбаруудад гарсан шинэ ололт, мэдлэг, тулгамдаж буй асуудлын талаар тэргүүлэх судлаачдын хийж буй их бүрэн үнэлэлт дүгнэлтийг хэвлэн нийтлэж байгаа бөгөөд Био-анагаах, Биологи, физик, нийгмийн ухааны нийт 46 чиглэлээр сэтгүүл хэвлэн гаргадаг.



### 4. THE PROCEEDINGS OF THE NATIONAL ACADEMY OF SCIENCES OF THE UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын өндөр импакттай цөөхөн сэтгүүлийн нэг. Монгол улсын аль ч компьютерээс үнэгүй нэвтрэх боломжтой.



## 5. jstor

1995 онд байгуулагдсан. 30,000 гаруй ном, сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг үзэх боломжтой мэдээллийн сан юм.



## 6. SPIE Digital Library

1962 оноос хойш гарсан 432,000 сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлын өгүүллүүдийг их сургуулийн сүлжээнээс үнэгүй унших боломжтой.



## 7. THE GEOLOGICAL SOCIETY OF LONDON

Лондоны Геологийн Нийгэмлэгийн сэтгүүлүүдийг унших боломжтой.



## 8. MATHSCINET

Америкийн Математикийн Нийгэмлэгээс олон улсын математикийн сэтгүүлүүдэд нэгдсэн магадлагаа хийж, үнэлэлт дүгнэлт өгдөг мэдээллийн сан.

## 9. Sage publisher

Sage publisher нь хүн төрөлхтний хөгжилд хэрэгтэй мэдлэгийг дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор анх 1965 онд байгуулагдсан. Одоогоор Sage нь шинжлэх ухааны өргөн цар хүрээг хамарсан шинэлэг, өндөр чанартай агуулга бүхий 1000 гаруй сэтгүүлийг унших боломжтой.



## 10. ecological society of america

Америкийн Экологийн Нийгэмлэгийн 100 жилийн ойг тохиолдуулан тус нийгэмлэгийн эрхлэн гаргадаг сэтгүүлүүдийн хамгийн өндөр импакт бүхий өгүүллүүдээ үнэгүй уншуулж байна.

## 11. springer



1997 оноос хойших 1800 гаруй сэтгүүлийг чөлөөтэй унших бөгөөд манай улсын 5 их сургууль мөн Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдэд дээрх эрх нээгдсэн болно.

МУИС-ийн сүлжээнээс хэрэглэгчийн нэр, нууц үг шаардаж нэвтрэх сангууд (**мэдээллийг номын сангаас авах**).



### 1. AGORA

2006 онд байгуулагдсан бөгөөд 60 гаруй хэвлэлийн газрын 21,000 гаруй ном, сэтгүүл болон бусад нэмэлт материалыг үзэх боломжтой мэдээллийн сан юм.



### 2. ARDI

2009 онд байгуулагдсан бөгөөд 17 хэвлэлийн газрын 20,000 гаруй ном, сэтгүүл болон судалгааны ажлыг үзэх боломжтой мэдээллийн сан.



### 3. hinari

2002 онд байгуулагдсан бөгөөд 190 гаруй хэвлэлийн газрын 58,000 гаруй материалыг үзэх боломжтой мэдээллийн сан.



### 4. OARE

(OARE) нь 2006 оны 10-р сард байгуулагдсан бөгөөд НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр болоод томоохон хэвлэлийн газруудтай хамтран, хөгжиж буй орнуудад байгаль орчны чиглэлийн судалгааны бүтээлүүдийг хүргэдэг үйлчилгээ юм.